

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46.1 дүгээр зүйл, “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2022 онд ашигтай ажилласан боловч банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд “2022 оны ногдол ашиг хуваарилахгүй тухай” мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Чанцалдулам-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Б.Наранзуул

Б.НАРАНЗУЛ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 62, 64, 65, 67 дугаар зүйлүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2023 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн 10.00 цагт** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Эв нэгдлийн гудамж-19/1, өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр, хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Б.Наранзулыг томилсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Дарга
Гишүүд

А.Амаржаргал
Б.Алтанцэцэг
Д.Цэрэндэжид

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б. Наранзуул

Б.НАРАНЗУЛ



ТУЗ-ийн 2023 оны 02-р сарын 24-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт- 1

“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2023 оны ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

№	Хэлэлцэх асуудал	Танилцуулах хүн	Хугацаа
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах	Б.Наранзул	30 мин
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах	Б.Наранзул	5 мин



ТУЗ-ийн 2023 оны 02-р сарын 24-ний өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт- 2

**“Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал
хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам, бүртгэлийн өдөр,
хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох
баримт бичгийн жагсаалт**

1. “Хөнгөн бетон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал хуралдуулах зарыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг ээлжит хурал хуралдуулах зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 дахь өдөр буюу 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байна.

3. Хувьцаа эзэмшигчид нь ээлжит хурлыг зарласан үед дараахь баримт бичигтэй танилцаж болно. Үүнд:

1. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан
2. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй талаар

--ooOoo--

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

Саналын хуудасны
загвар батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 71.3 дугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Хөнгөн бетон”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлаар шийдвэрлэх асуудлаар өгөх “Саналын хуудасны загвар”-ыг “Хавсралт №1”-ээр баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б. Наранзул

Б.НАРАНЗУЛ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 24-ний өдрийн 03-р тогтоолын “Хавсралт-1”

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2023 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: “Хөнгөн Бетон” Хувьцаат Компани
Хурал хуралдах газар, өдөр цаг : ХУД, 3-р хороо, Эв-Нэгдлийн гудамж-19/1,
“Хөнгөн бетон” ХК-ийн оффисын байр,
2023 оны 04-р сарын 05-ны 10:00 цаг

Хувьцаа эзэмшигчийн овог: Нэр:

Хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшдэг хувьцааны тоо:

Шийдвэрлэх асуудал ба санал өгөх хэлбэр

Д/д	Шийдвэрлэх асуудал	Санал өгөх хэлбэр/ сонгосон саналыг + тэмдэгээр тэмдэглэнэ.		
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах			

Санал өгсөн Хувьцаа эзэмшигч...../...../

2023 оны 02-р сар 24-ний өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“ХӨНГӨН БЕТОН” ХК
Хаяг, утас	УБ, ХУД 3-р хороо, Үйлдвэр /17061/ Эв нэгдлийн гудамж 19/1, Утас: 88887830, 80060773, e-mail: naranzul@hbt.mn, info@hbt.mn
Хурал хуралдах өдөр цаг:	2023 оны 04-р сарын 05-ны өдрийн 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	ХУД 3-р хороо, Үйлдвэр /17061/ Эв нэгдлийн гудамж 19/1, Хөнгөн бетон ХК-ийн өөрийн байранд
Хурлын төрөл:	Ээлжит ✓ Ээлжит бус
Хурал зарлагч:	ТУЗ ✓ ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/ Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2023 оны 02-р сарын 24
Олон нийтэд зарлах огноо:	2023 оны 02-р сарын 28, 03-р сарын 15
Бүртгэлийн өдөр:	2023 оны 03-р сарын 15
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2023 оны 03-р сарын 15
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	Б.Наранзул
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	А.Амаржаргал, Б.Алтанцэцэг, Д.Цэрэндэжид
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

Б. Наранзул
..... /Б.НАРАНЗУЛ/

2023 оны 02-р сарын 24-ний өдөр